



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Завхан аймгийн ЗДТГ-ын дэргэдэх теле камерын хяналтын дэд төв" ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ЗАА-2026/001/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)



Улиастай сум  
2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Аудитор: О.Алтансүвд

Утас: 88009224

Цахим хаяг: [altansuvdoyu@audit.gov.mn](mailto:altansuvdoyu@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Улиастай сум, Завхан аймаг 81090  
Утас/Факс: 7046-3612  
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.02.13 № 216  
танай \_\_\_\_\_ -нм № \_\_\_\_\_ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ТЕЛЕ КАМЕРЫН  
ХЯНАЛТЫН ДЭД ТӨВИЙН  
ДАРГА Б.ДАГВАСАМБУУД

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Теле камерын хяналтын дэд төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх теле камерын хяналтын дэд төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Теле камерын хяналтын дэд төв нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогоор 66,935.1 мянган төгрөг, нийт зардлын гүйцэтгэл 64,813.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Теле камерын хяналтын дэд төвийн эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэрээс 4,734.0 мянган төгрөгийн хоол, унааны нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон, албан хаагчдад 5 дугаар сард бодогдсон цалингаас 113,280 төгрөгийг илүү шилжүүлсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасан заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Шилэн дансны цахим мэдээллийн санд бүртгүүлээгүй, холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлээгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2024 оны 1 сарын 1	2024 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		2,122,077.68
1.1.02	Дансны авлага		
1.1.06	Бараа материал		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>2,122,077.68</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө		
1.2.02	Биет бус хөрөнгө		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,122,077.68</b>
2.1.1.01	Дансны өглөг		
2.1.1.03	Татварын өр		
2.1.1.04	НДШ - ийн өглөг		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр		
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		
2.3.02	- хувийн		
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.09	Хуримтлагдсан ашиг		
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг		2,122,077.68
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг		
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>		
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>2,122,077.68</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>01</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>0.0</b>	<b>66,935,125.00</b>
<b>02</b>	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>0.0</b>	<b>64,813,047.32</b>
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>0.0</b>	<b>2,122,077.68</b>
08	Бусад орлого	0.0	0.0
<b>08.1</b>	<b>Орлогын дүн</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0.0	0.0
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>0.0</b>	<b>2,122,077.68</b>
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.0	0.0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0	0.0
17.1	Олз, гарзын дүн	0.0	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	0.0	2,122,077.68
19	Орлогын татварын зардал	0.0	0.0
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>0.0</b>	<b>2,122,077.68</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>0.0</b>	<b>2,122,077.68</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын	Дахин үнэлгээний	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
-----	----------	----------------	------------------	-------------------	--------------------------------

		оруулсан капитал	нөөц		нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,122,077.68	2,122,077.68
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>2,122,077.68</b>	<b>2,122,077.68</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	00.00	<b>66,935,125.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	00.00	<b>66,935,125.00</b>
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	00.00	00.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	00.00	00.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	00.00	00.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	00.00	00.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	00.00	00.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	00.00	<b>64,813,047.32</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	00.00	63,106,787.32
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	00.00	1,706,260.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	00.00	00.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	00.00	00.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	00.00	00.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	00.00	00.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	00.00	00.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	00.00	00.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	00.00	00.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	00.00	2,122,077.68
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	00.00	00.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	00.00	00.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	00.00	00.00
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	00.00	2,122,077.68
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	2,122,077.68

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин	65,228,865.0	63,106,787.32	0.00
2	НДШ	1,706,260.00	1,706,260.00	0.00
	<b>Нийт дүн</b>	<b>66,935,125.00</b>	<b>64,813,047.32</b>	<b>0.00</b>

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4,847.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 113.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 4,734.0 мянган төгрөгийн албан шаардлага, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 1 заалт зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 4,847.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалтай" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт:

Алба хаагчдад тайлант оны 5 дугаар сард бодогдсон цалингаас 113,280 төгрөгийг илүү шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага:

Эрх бүхий албан тушаалтаны тушаал шийдвэрээс 4,734.0 мянган төгрөгийн хоол, унааны нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон зөрчилд албан шаардлага өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим мэдээллийн санд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй" зассантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны цахим хуудсанд холбогдох байгууллагын төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

**Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан				Буруу тусган илэрхийлсэн				/мянган төгрөгөөр/					
	Нийт алдаа		Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан		Зөрчлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн														

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж				Хариуцлага тооцуулах албан шаардлага				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал					
	Нийт зөрчил		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эрх бүхий албан тушаалтаны тушаал шийдвэрээс 4,734.0 мянган төгрөгийн хоол, унааны нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон байна.	1	4,734.0						1	4,734.0																	
Алба хаагчдад тайлант оны 5 дугаар сард бодогдсон цалингаас 113,280 төгрөгийг илүү шилжүүлсэн байна.	1	113.3			1	113.3																				
Дүн	2	4,847.3	1	113.3	1	4,734.0																				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж					
	Нийт зөрчил		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил			1	0											1	0		
Шилэн дансны цахим мэдээллийн санд бүртгүүлээгүй, холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлээгүй байна.			1	0											1	0		
Дүн			1	0											1	0		
Нийт дүн			1	0											1	0		

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчлгүй	Хязгарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түгвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Аудит хийсэн хэлбэр				
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1				1			
2	Төсөл, хөтөлбөр									
3	ЗГТС									
4	ТТЗ									
5	ТЕЗ									
	<b>НИЙТ</b>	<b>1</b>		<b>1</b>			<b>1</b>			

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

О.АЛТАНСУВД

Огноо: 2026-03-13